

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ЗҮҮН БҮС ДЭХ ГАЗРЫН
2020 ОНЫ НЭГДҮГЭЭР САРЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
/2019.12.11-2020.02.31/

2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр

Дорнод аймаг

Д/д	Бүтээгдэхүүний нэр	Хийгдэх ажил	Биелэлт	Хувь
1	2	3	4	5
Нэг. Захиргаа, удирдлагын чиглэлээр				
1	Байгууллагын даргын болон бусад холбогдох нэгжээс ирүүлсэн үүрэг даалгавар, албан даалгавар, зөвлөмжийг хэрэгжүүлж биелэлтийг гаргаж хүргүүлэх	а/ Албан хаагчдад хүргүүлж, үүрэг даалгавар өгөх б/ Хэрэгжилтийг тухай бүр хангах в/ Холбогдох албан тушаалтанд тайлагнах	Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст бүсийн газрын 11 дүгээр сарын үйл ажиллагааны тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, инфо мэдээ, байгууллагын даргын 2017, 2018, 2019 оны албан даалгавруудын биелэлт, 02 дугаар сард хийх ажлын төлөвлөгөөг холбогдох албан хаагчид тус тус хүргүүлсэн. 2019 оны 12 дугаар сарын 29-ны өдрөөс 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрүүдэд шинэ жилийн баяр болохтой холбоотойгоор амралтын олон хоногууд тохиож байсан тул тус өдрүүдэд аюулгүй байдлыг хангах үүднээс хариуцлагатай жижүүрийн хуваарь баталж ажилласан. Авилгын эсрэг хуульд заасан ХАСХОМ бөглөх эрх бүхий тус газраас 14-н албан хаагч хөрөнгө орлогын мэдүүлгээ хуулийн хугацаанд бүрэн бөглөж дууссан.	100%
2	Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэлгээний багт танилцуулах, Байгууллагын даргаар гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулах	а/ Батлагдсан загварын дагуу байна б/ Оновчтой төлөвлөсөн байна в/ Баталгаажуулсан байна	Дарга Б.Тамир бүсийн газрын төрийн захиргааны албан хаагчдын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг байгууллагын үнэлгээний багт танилцуулсан. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг хангалтгүй үнэлүүлсэн албан хаагч байхгүй. 2020 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 01 дүгээр сарын 24-ний өдөр Байгууллагын даргаар баталгаажуулсан.	100%

ТАНИЛЦСАН:
ГАЗРЫН ДАРГА

Б.ТАМИР

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
МЭРГЭЖИЛТЭН

А.НЭМЭХБАЯР